



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 10 сарын 12 өдөр

Дугаар A/601

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2./а/, 29.2 дахь заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны IV хуралдааны 02 дугаар тогтоол, 2017 оны 5 сарын 26-ны VII хуралдааны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хүчтэй аадар борооны улмаас эвдэрсэн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн сүлжээний тог баригч, үерийн улмаас үүссэн хог шороог цэвэрлэхэд зарцуулсан шатахууны зардал, Цагдаагийн газрын барилгын гадна хаявч сэргээн засварлах, 10 дугаар цэцэрлэгийн гадна инженерийн шугамд гэмтэл гарсныг засварлаж хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.


2.Дээрх ажилд шаардагдах 27039795 /Хорин долоон сая гучин есөн мянга долоон зуун ерөн таван/ төгрөгийг Болзошгүй аварийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын захирагчийн алба /н.Түмэнжаргал/-д даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны
10 дугаар сарын 12-ны өдрийн
4/601 дугаар захирамжийн хавсралт

**БАРИЛГА, ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ЗАСВАРЫН
АЖЛЫН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ**

№	Зардлын нэр	Зардал / төгрөг/
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн сүлжээний тог баригчийг солих	17450000
2	10-р цэцэрлэгийн гадна инженерийн шугам сүлжээний засварын ажил	2617991
3	2017оны 8 сарын 14-ний өдрийн хүчтэй аадар борооны улмаас үүссэн хог хаягдлыг цэвэрлэсэн ажлын шатахууны зардал /Хот тохижуулах газар/	1968750
4	Цагдаагийн газрын барилгын гадна хаявч сэргээн засварлах	5003054
	Дүн	27039795